



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 1124

Номгон

Баянхонгор аймгийн төлөөлөгчдийг БНХАУ-д
ажиллуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол улсын дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журмын 2.2.2, 2.2.4, 2.2.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр хэсгийн 4.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Баянхонгор аймгаас Бүгд Найрамдах Хятад Ард улсын ӨМӨЗО-ны Альшаа аймгийн Эзнээ хошуу, Гансу мужийн Жючуан хот, Ланжоу хот, Нинша Хуйн Өөртөө Засах Орны Енчуан хотод 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс 03 дугаар сарын 24-ний өдрийг хүртэлх хугацаанд ажиллах дараах албан хаагчдыг томилсугай.

- 1.Засаг даргын Орлогч Б.Батсуурь
- 2.Баянхонгор сумын Засаг дарга бөгөөд Хотын Захирагч Г.Энхбаяр
- 3.Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга П.Отгонбаяр
4. Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Л.Мандал
- 5.Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Алтанцэцэг
- 6.Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч У.Балжинням
- 7.Соёл урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Азбаясгалан
- 8.ИНЕГ-ын харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын дарга Д.Мөнхжаргал
9. Баянхонгор аймгийн МАН-ын хорооны дэд дарга , аймгийн ИТХ-ын төлөөлөгч Б.Энхтүвшин

542310291

2.


10. Ингэн-Эрдэнэ ОНӨҮГ-ын дарга Д.Хишигбаяр

11. Ингэн-Эрдэнэ ОНӨҮГ-ын ажлын албаны дарга Ц.Дашцэрэн

12. Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Гадаад харилцааны асуудал хариуцсан мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Лхаасүрэн

2. БНХАУ-ын холбогдох албан төлөөлөгчидтэй уулзсан, хөдөө аж ахуй, хот байгуулалтын талаар туршлага судалсан тухай тайлан мэдээллийг хүлээн авч, үр дүнг тооцож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН